

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

202... оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан), Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газар (Б.Алимаа)-т, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв (Д.Нарансүх)-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 2015 оны "Журам батлах тухай" А/234 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

Ж.ЧИНБҮРЭН

Т.АУБАКИР

Эрүүл мэндийн сайд,
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
хамтарсан 202... оны дугаар сарын-ны өдрийн
.....дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙГ БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх, өгөгдлийн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийж, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэхэд энэ журам болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах журам”, “Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ тайлан гаргах журам”-ыг тус тус мөрдөнө.

1.3.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага энэхүү журмыг хэрэгжүүлэхэд ажил олгогч, эрүүл мэндийн байгууллагад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

1.4.Мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо мэдээг эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ тайланд нэгтгэх асуудлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төв хариуцна.

Хоёр. Мэргэжлээс шалтгаалсан өвчний бүртгэл, мэдээлэл

2.1.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага нь ажилтанд мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэг илэрсэн талаарх мэдэгдэл, хүсэлтийг дараах талуудаас хүлээн авч, хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, үнэлгээний тайлан, эмнэл зүйн үзлэг, шинжилгээнд үндэслэн шийдвэрлэнэ.

2.1.1.мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагын мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын эмнэлэг;

2.1.2.эрүүл мэндийн байгууллага;

2.1.3. ажил олгогч;

2.1.4.ажилтан эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч.

2.2.Эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамрагдсан иргэнд мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд энэ журмын нэгдүгээр хавсралтын дагуу мэдээллийг ажлын 20 хоногт багтаан мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэнэ.

2.3.Ажил олгогч ажилтанд мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд энэ журмын хоёрдугаар хавсралтын дагуу мэдээллийг тухай бүр мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэнэ.

2.4.Ажилтанд мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд тухайн ажилтан эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч нь мэргэжлээс

шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагад хандаж, онош тодруулах үзлэг, шинжилгээнд хамрагдаж болно.

2.5.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага нь мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэг бүхий тохиолдлын онош тодруулах асуудлыг ажлын 15 өдөрт багтаан шийдвэрлэж, хариуг онош тодруулах хүсэлт гаргасан талд хүргүүлнэ.

2.6.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага шаардлагатай тохиолдолд онош тодруулах зорилгоор тухайн иргэнд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, үнэлгээг нэмэлтээр хийж болно. Энэ тохиолдолд онош тодруулах хугацааг ажлын 20 хоногоор нэг удаа сунгаж болно.

2.7.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага онош баталгаажуулсан мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг хөдөлмөрийн чадвар алдсан эсэхээс үл хамааран энэ журмын гуравдугаар хавсралтад заасан жагсаалтын дагуу бүртгэж, мэргэжлээс шалтгаалсан өвчний өгөгдлийн санг бүрдүүлнэ.

2.8. Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага хөдөлмөрийн чадвар алдалт үүсгэсэн мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдлыг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн Мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хөдөлмөр чадвар алдалтын хувь, хугацааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны А/152, А/388 дугаар тушаалын дагуу тогтоолгоно.

2.9. Ажил олгогч хөдөлмөрийн чадвар алдаагүй мэргэжлээс шалтгаалсан өвчний тохиолдолд тухайн ажилтанд мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсэхэд нөлөөлсөн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, шалтгааныг арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд хөдөлмөрийн эрүүл мэндийн эмчийн дүгнэлт, зөвлөгөөнд үндэслэн хөдөлмөр зохицуулалт хийнэ.

2.10.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 20-ны өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлнэ.

2.11.Эрүүл мэндийн хөгжлийн төв мэргэжлээс шалтгаалсан өвчний тоо мэдээг эрүүл мэндийн салбарын албан ёсны статистик мэдээ тайланд нэгтгэх асуудлыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

Гурав. Мэргэжлээс шалтгаалсан өвчний өгөгдлийн сан

3.1.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага “Мэргэжлээс шалтгаалсан өвчний өгөгдлийн сан” (цаашид “өгөгдлийн сан” гэх)-г бүрдүүлнэ. Энэхүү өгөгдлийн сан нь Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 16.1-д заасан сантай уялдаж ажиллана.

3.2.Өгөгдлийн сангийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага болон

нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран хариуцна.

3.3.Өгөгдлийн сан дараах мэдээллийг агуулна. Үүнд:

3.3.1.Ажилтны хувийн мэдээлэл: Овог, нэр, регистрийн дугаар, хүйс, нас, иргэншил, хаягийн харьяалал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал, амь нас эрүүл мэндийн нэмэлт даатгалд даатгагдсан эсэх мэдээлэл;

3.3.2.Ажил эрхлэлтийн мэдээлэл: Ажил олгогчийн нэр, хаягийн харьяалал, эдийн засгийн салбарын ангилал, дэд салбар, албан тушаал, ажил эрхэлсэн хугацаа, ажил эрхлэлтийн байдал;

3.3.3.Хөдөлмөрийн нөхцөлийн мэдээлэл: Мэргэжлээс шалтгаалсан өвчин үүсгэх эрсдэлтэй хэвийн бус нөхцөлд ажилласан хугацаа (хүчин зүйл бүрээр),

3.3.4.Эмнэл зүйн мэдээлэл: Мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэг илэрсэн огноо, анх оношилсон эрүүл мэндийн байгууллага, (үндсэн болон хавсарсан) онош, өвчний олон улсын 10 дугаар ангилал;

3.3.5.Онош баталгаажуулалт: Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагын дүгнэлт, баталгаажсан (үндсэн болон хавсарсан) онош, өвчний олон улсын 10 дугаар ангилал, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, хөдөлмөр зохицуулалт хийсэн эсэх, сэргээн засах тусламж, үйлчилгээ хийгдэх эсэх;

3.3.6.Ажил олгогчийн хэрэгжүүлсэн арга хэмжээ: ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг хэвийн (эрсдэлгүй) болгож сайжруулсан, ажлын байрыг сольсон, дахин мэргэшүүлэх сургалтад хамруулж шинэ ажлын байраар хангасан байдал;

3.3.7.Хяналтын үзлэг, сэргээн засах тусламж: хяналтын үзлэг болон сэргээн засах эмчилгээ, сувилалд хамрагдсан байдал;

3.3.8.Хөдөлмөрийн чадвар алдсан тохиолдлын мэдээлэл: хөдөлмөрийн чадвар алдсаны нөхөн төлбөр авсан эсэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр авдаг эсвэл өндөр настны тэтгэвэр тогтоолгосон эсэх, хөдөлмөр эрхэлдэг эсэх;

3.3.9.Нас баралтын мэдээлэл: мэргэжлээс шалтгаалсан өвчтэй хүн нас барсан бол нас барсан огноо, шалтгаан (мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаантай эсэх).

3.4.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага өгөгдлийн санд улирал тутамд дүн шинжилгээ хийж, дараа улирлын 20-ний өдрийн дотор олон нийтэд мэдээлнэ.

Дөрөв. Хөдөлмөр зохицуулалт, сэргээн засах тусламж

4.1.Ажил олгогч Хөдөлмөрийн тухай хуулийн 120 дугаар зүйлд заасны дагуу мэргэжлээс шалтгаалсан өвчтэй ажилтныг ажлын байрны хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангана.

4.2.Ажил олгогч хэвийн бус хөдөлмөрийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж хэвийн болгох арга хэмжээг богино хугацаанд

хэрэгжүүлэх боломжгүй бол мэргэжлийн эмчийн хийсэн ажил, хөдөлмөрийн тохиороны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн хөдөлмөр зохицуулалт хийнэ.

4.3.Хөдөлмөр зохицуулалт хийхэд ажилтны үндсэн цалинг бууруулахгүйгээр эрсдэлгүй ажлын байранд шилжүүлэн ажиллуулах, ажлын цагийг хорогдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.4.Хөдөлмөр зохицуулалт хийхтэй холбоотойгоор ажилтныг дахин мэргэшүүлэх сургалтад хамруулах бол уг сургалттай холбоотой бүх зардлыг ажил олгогч хариуцна.

4.5.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага шинээр бүртгэгдсэн мэргэжлээс шалтгаалсан өвчтэй иргэнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах шаардлагатай сэргээн засах тусламж, үйлчилгээг тодорхойлно.

4.6.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага өгөгдлийн санд бүртгэгдсэн мэргэжлээс шалтгаалсан өвчтэй иргэдийг жилд нэгээс доошгүй удаа эрүүл мэндийн хяналтын үзлэгт хамруулж, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулсан сэргээн засах төв болон сувилалд илгээнэ.

4.7.Мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага мэргэжлээс шалтгаалсан өвчтэй иргэнд үзүүлж буй сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд жил бүр дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулна.

Тав. Ажил олгогчийн хүлээх үүрэг

5.1.Ажил олгогч мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх, мэдээлэх болон түүнээс шалтгаалсан хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэхэд дараах үүргийг хүлээнэ.

5.1.1.үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлтэй ажил, мэргэжилд ажилладаг ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгт эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу хамруулах;

5.1.2.ажилтны эрүүл мэндийн үзлэгээр илэрсэн мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэгтэй тохиолдлыг энэхүү журмын дагуу мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэж, онош тодруулах;

5.1.3.мэргэжлээс шалтгаалсан өвчний оношийг тогтоох үйл явцад шаардлагатай ажилтны эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ болон ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, үнэлгээний мэдээллээр эрүүл мэндийн байгууллагыг хангах;

5.1.4.ажилтны эрүүл мэндийн үзлэг хийсэн эрүүл мэндийн байгууллага болон мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагын дүгнэлт, зөвлөмжийн дагуу ажилтны ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, хөдөлмөр зохицуулалт хийх;

5.1.5.ажилтан хөдөлмөрийн нөхцөлтэй нь холбоотойгоор мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэг илэрсэн тухай мэдэгдэж, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдах хүсэлт гаргасан тохиолдолд ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдахад цалинтай чөлөө олгох, шаардлагатай зардлыг хариуцах.

5.1.6.мэргэжлээс шалтгаалсан өвчний батлагдсан тохиолдлыг ажилтны эрүүл мэндийн мэдээлэлд оруулж, бүртгэл хөтөлнө.

Зургаа. Бусад

6.1.Энэхүү журамд заасан шаардлагыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

Эрүүл мэндийн сайд,
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
хамтарсан 202... оны дугаар сарын-ны өдрийн
.....дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ШИНЖ БҮХИЙ ТОХИОЛДЛЫГ ОНОШ ТОДРУУЛАХААР ИЛГЭЭХ
МАЯГТ**

(Эрүүл мэндийн байгууллагаас)

1.Илгээсэн эрүүл мэндийн байгууллагын мэдээлэл	
1.1.Нэр: 1.2.Харилцах хаяг, утас, мэйл 1.3.Илгээсэн огноо:	
2.Ажилтны мэдээлэл	
2.1.Овог нэр: 2.2.Регистрийн дугаар 2.3.Нас, хүйс 2.4.Харьяалал: 2.5.Гэрийн хаяг, утасны дугаар:	
3.Ажил эрхлэлт, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн мэдээлэл	
3.1.Ажил олгоогчийн нэр 3.2.Эдийн засгийн салбар, дэд салбар: 3.3.Хэлтэс, нэгжийн нэр: 3.4.Албан тушаал, ажлын чиг үүрэг: 3.5.Тухайн ажилд ажилласан хугацаа 3.6.Нийт ажилласан жил 3.7.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл Эрсдэлгүй хэвийн нөхцөлд ажилласан хугацаа: Дунд эрсдэлтэй хэвийн нөхцөл ажилласан хугацаа: Өндөр эрсдэлтэй хэвийн бус ажилласан хугацаа: Ноцтой эрсдэлтэй хэвийн бус ажилласан хугацаа: Өндөр эрсдэлтэй хөдөлмөрийн нөхцөлийн хүчин зүйл: Ноцтой эрсдэлтэй хөдөлмөрийн нөхцөлийн хүчин зүйл:	
4.Эмнэл зүйн мэдээлэл	
4.1.Илэрсэн шинж тэмдэг 4.2.Шинж тэмдэг анх илэрсэн огноо: 4.3.Урьдчилсан онош /Өвчний ОУ-ын 10-р ангилаар/: 4.4.Хийгдсэн үзлэг, шинжилгээ: 4.5.Мэргэжлээс шалтгаалах өвчний шинж тэмдэг илрүүлсэн хэлбэр 4.6.Ажил, хөдөлмөрийн тохирооны дүгнэлт 4.7.Ажилтны хөдөлмөрийн чадварыг алдагдсан эсэх	☐ Ажилтны эрүүл мэндийн урьдчилсан үзлэг ☐ Ажилтны эрүүл мэндийн хугацаат үзлэг ☐ Ажилтны эрүүл мэндийн нэмэлт үзлэг ((ажилд эргэн орох үеийн, ажлын нөхцөл солих үеийн, ажлаас гарах үеийн) ☐ эрүүл мэндийн бусад үзлэг ☐ Ажилд тохирно ☐ Ажилд түр тохирно ☐ Ажилд хязгаарлалттай тохирно ☐ Түр хугацаанд ажлаас чөлөөлсөн ☐ Ажилд тохирохгүй ☐ Тийм ☐ Үгүй
5.Ажилтны зөвшөөрөл	
☐ Миний эрүүл мэндийн мэдээллийг тандалт, онош тодруулах зорилгоор ашиглахыг зөвшөөрч байна	
Ажилтны гарын үсэг: _____ Огноо: _____	
6.Маягтыг хөтөлж, онош тодруулахаар илгээсэн эмчийн мэдээлэл	
6.1.Эмчийн овог, нэр: 6.2.Албан тушаал 6.3.ХЭМ/МШӨ судлалаар мэргэшсэн эсэх Эмчийн гарын үсэг: _____ Огноо: _____	

Тайлбар: Ажилтны асуумж, өвчний түүх, ажлын байрны өртөлтийн түүх /жил,сараар/, давтамж, өртөлтийн төрөл, хийгдсэн лабораторийн болон багажийн шинжилгээний хариу, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайланг хавсралтаар илгээнэ

Эрүүл мэндийн сайд,
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
хамтарсан 202... оны дугаар сарын-ны өдрийн
.....дугаар тушаалын гуравдугаар хавсралт

**МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ШИНЖ БҮХИЙ ТОХИОЛДЛЫГ ОНОШ ТОДРУУЛАХААР ИЛГЭЭХ
МАЯГТ**

(Ажил олгогчоос)

1.Ажил олгогчийн мэдээлэл	
1.1.Байгууллагын нэр:	
1.2.Харилцах хаяг, утас, мэйл	
1.3.Үйл ажиллагааны чиглэл(эдийн засгийн салбар, дэд салбарын ангиллаар)	
2.Ажилтны мэдээлэл	
2.1.Овог нэр:	
2.2.Регистрийн дугаар:	
2.3.Нас, хүйс:	
2.4.Харьяалал:	
2.5.Гэрийн хаяг, утасны дугаар:	
3.Ажил эрхлэлт, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн мэдээлэл	
3.1.Ажил олгогчийн нэр:	
3.2.Эдийн засгийн салбар, дэд салбар:	
3.3.Хэлтэс, нэгжийн нэр:	
3.4.Албан тушаал, ажлын чиг үүрэг:	
3.5.Тухайн ажилд ажилласан хугацаа	
3.6.Нийт ажилласан жил	
3.7.Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл	
Эрсдэлгүй хэвийн нөхцөлд ажилласан хугацаа:	
Дунд эрсдэлтэй хэвийн нөхцөл ажилласан хугацаа:	
Өндөр эрсдэлтэй хэвийн бус ажилласан хугацаа:	
Ноцтой эрсдэлтэй хэвийн бус ажилласан хугацаа:	
Өндөр эрсдэлтэй хөдөлмөрийн нөхцөлийн хүчин зүйл:	
Ноцтой эрсдэлтэй хөдөлмөрийн нөхцөлийн хүчин зүйл:	
4.Мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэг	
4.1.Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг сэжиглэж буй шалтгаан/баримт	
4.2.Шинж тэмдэг анх илэрсэн огноо:	
4.3.Сэжиглэж буй МШӨ-ний онош тодруулахаар эрүүл мэндийн байгууллагад хандсан эсэх	☐ Тийм ☐ Үгүй
4.4.Ажилтны хамгийн сүүлд эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан огноо, үзлэг хийсэн эрүүл мэндийн байгууллагын нэр	
5.Ажил олгогчийн хүсэлт	
☐ МШӨ-ний онош тодруулах шаардлагатай эрүүл мэндийн үзлэг шинжилгээ хийлгэхээр хүсэлт гаргаж	
☐ МШӨ-ний онош тодруулах хүсэлтийг гаргаж эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, үнэлгээний тайлангийн хамт хүргүүлэв	
Эрүүл мэндийн үзлэг хийсэн байгууллагын нэр, харилцах утас, хариуцсан эмчийн нэр:	
Ажил олгогчийн үсэг:	Огноо:

Эрүүл мэндийн сайд,
Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
хамтарсан 202... оны дугаар сарын-ны өдрийн
.....дугаар тушаалын дөрөвдүгээр сар хавсралт

МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ЖАГСААЛТ

1.Мэргэжлээс шалтгаалсан амьсгалын замын эмгэг		Өвчний олон улсын (ICD-10) ангиллын код
Уушги тоосжих өвчин		
1.1	Антракоз /антракосиликоз/	J60
1.2	Асбестоз	J61
1.3	Силикоз	J62
1.4	Сидероз, Цементоз	J63
1.5	Пневмоканиоз /холимог тоосоор үүсгэгдсэн/	J64
1.6	Силикотуберкулёз	J65
1.7	Биссиноз	J66
Тоосжилтын болон, хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл		
1.8	Тоосжилтын болон хордлогын шалтгаант гуурсан хоолойн архаг үрэвсэл	J68
1.9	Тоосжилт, харшил, хордлогын шалтгаант багтраа	J68.4
2.Мэргэжлээс шалтгаалсан хордлого		
Химийн бодисын архаг хордлогын улмаас үүсэх эмгэг		
2.1	Хүнд металлын хордлого /хар тугалга, хүнцэл, мөнгөн ус, хром, кадми, зэс, цайр, цагаан тугалга, берилли тэдгээрийн нэгдлүүд, бусад металлууд/	T56
2.2	Идэмхий бодисын хордлого /фенол, фенолын уламжлалууд, бусад идэмхий органик бодисууд, идэмхий хүчил, хүчил төст нэгдлүүд, идэмхий шүлт, шүлт төст нэгдлүүд /	T54
Ароматик бодисуудын хордлого		
2.3	Ханасан ба үнэрт устөрөгчийн галогены уламжлалын хордлого /тетрахлорт нүүрстөрөгч, хлороформ,	T53
Цочроогч, боогдуулагч бодисын /хий, уур/ хордлого		
2.4	Хий ба ууршилттай цочроогч, боогдуулагч бодисуудын хордлого /азотын исэл, хүхрийн давхар исэл, аммиак, нулимс асгаруулагч хий, хлор, фтор, фторт устөрөгч, хүхэрт устөрөгч, нүүрсхүчлийн давхар исэл, бусад хий, утаа, уур/	T59
Пестицидийн хордлого		
2.5	Пестицидийн хордлого /Органик фосфат ба карбамат, хлорорганик, фосфорорганик агуулсан шавж устгагчууд, гербицид, фунгицид, родентицид, бусад деститцүүд/	T60
Органик бус бодисын хордлого		
2.6	Бусад органик бус бодисын хордлого /марганц тэдгээрийн нэгдлүүд, устөрөгчийн цианид, бусад органик бус нэгдлүүд/	T57
2.7	Нүүрстөрөгчийн дан ислийн хурц хордлогын үлдэц	T58
Органик хүчлүүд ба түүний нэгдлүүд		
2.8	Органик уусгагчууд /шатахууны нэгдлүүд, бензин, бензиний нэгдлүүд, толоул, ксилол, нафталингликол, кетон, бусад органик уусгагчууд/	T52
3.Мэргэжлээс шалтгаалсан арьс, харшлын өвчин		
3.1	Мэргэжлээс шалтгаалсан хавьтал, харшлын дерматит	L23
3.2	Мэргэжлээс шалтгаалсан энгийн хавьтлын цочролт дерматит	L24
4.Мэргэжлээс шалтгаалсан нүдний өвчин		
4.1	Мэргэжлээс шалтгаалсан зовхи салстын хурц болон архаг үрэвсэл /конъюнктивит/, нулимс дамжуулах замын эмгэг	H10 H11 H04
4.2	Мэргэжлээс шалтгаалсан эврэвчийн хурц болон архаг үрэвсэл, цагаа унах,	H17
4.3	Мэргэжлээс шалтгаалсан нүдний болрын эмгэг	H26

	/катаракта/	
4.4	Мэргэжлээс шалтгаалсан харааны мэдрэлийн үрэвсэл, болон хатангиршил	H46 H47
4.5	Мэргэжлээс шалтгаалсан нүдний даралт ихсэх эмгэг /хоёрдогч глаукома/	H40
4.6	Мэргэжлээс шалтгаалсан торовчийн эмгэг /миопия болон бусад/	H35 H52
4.7	Төрөлхийн өнгөт харааны гажигтай, хэвийн өнгөт хараа шаардагдах бүх төрлийн мэргэжил /бүх төрлийн жолооч, нисгэгч, лаборант, зураач болон бусад/.	H53.5 H53.0
5.Мэргэжлээс шалтгаалсан мэдрэлийн өвчин		
5.1	Хэсгийн, ерөнхий, хавсарсан доргион	T75
5.2	Цахилгаан соронзон талбай, лазер, радио долгионы нөлөөллөөс үүсэн өвчин	W85
5.3	Нурууны спондилопати /остеохондроз, спондилёз, ивэрхийн	G54
6.Мэргэжлээс шалтгаалсан чих, хамар, хоолойн өвчин		
6.1	Шуугианы нөлөөгөөр үүссэн сонсгол бууралт	H83.3
6.2	Мэргэжлээс шалтгаалсан өгүүлэх эрхтний эмгэг	J38 J38.0
6.3	Мэргэжлээс шалтгаалсан амьсгалын дээд замын эмгэг	J31 J34.8
7.Мэргэжлээс шалтгаалсан туяаны өвчин		
7.1	Мэргэжлээс шалтгаалсан цацраг идэвхт бодис болон рентген туяанаас үүссэн туяаны өвчин	W88- 91
8.Мэргэжлээс шалтгаалсан мэс заслын эмгэг		
8.1	Мэргэжлээс шалтгаалсан доод мөч, хэвлий, аарцгийн эрхтний вений бүдүүрэл	I83
8.2	Мэргэжлээс шалтгаалсан тохойн үений хэлбэр хөдөлгөөн алдагдах эмгэг	M21.2
8.3	Мэргэжлээс шалтгаалсан артерийн судасны олдмол нарийсал ба бөглөрөл	I74
8.4	Мэргэжлээс шалтгаалсан дээд мөчний бичил гэмтэл, давтагдсан ачааллаас үүссэн өвчнүүд / үений холбоосны өвчин, дээд мөчний мэдрүүлийн саа, шөрмөсний ба уутанцрын үрэвсэл/	M67.8
8.5	Мэргэжлээс шалтгаалсан тавхай хавтгайрах эмгэг	M21.4
Мэргэжлээс шалтгаалсан хавдрууд		
9.1	Мэргэжлээс шалтгаалсан хавдар	ICD-10 ангиллаар

---oOo---